Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашиглан тооцоолдог. Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны нийт хөрөнгийн 60 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн.	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид Банкны Зээлийн Үнэ Цэнийн Хүлээгдэж буй Алдагдал ("ЗҮЦХА")-ыг батлах, бүртгэх, хянах хяналтын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцоолох ЗҮЦХА-ын загварт банкны ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Арга зүйг үнэлэхдээ бид банкны ЗҮЦХА-ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын удирдлагын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан.

Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Зээлийн үнэ цэнийн бууралт	
Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Зээлийн Үнэ Цэнийн Хүлээгдэж буй Алдагдал ("ЗҮЦХА")-ын загварт суурилсан. Энэхүү ЗҮЦХА-ын загварын бүрэлдэхүүн хэсгүүд нь ихээхэн төсөөлөл, болон тооцоолол шаарддаг. Үүнд: • Санхүүгийн хөрөнгийн шатлал; • ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Чанаргүйдлийн Магадлал ("ЧМ") болон Алдагдалд Хүргэх Чанаргүйдэл ("АХЧ")-ийг сонгох; • Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; • ЗҮЦХА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон • Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.5 болон 3-д тус тус толилуулсан. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 10, 16 болон 34.2-д тус тус толилуулсан.	Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ЧМ, АХЧ болон ЧӨД -ийг тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн. Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан. Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан. Бид ЗҮЦХА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Банкны боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд: • Түүхэн ЧМ, АХЧ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; • Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; • ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан; • Үнэ цэнийн бууралтыг үнэлэх тусгайлан үнэлсэн зээлүүдээс сонгогдсон түүврүүдийн хувьд бид ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх Банкны таамаглалуудыг хянаж үзсэн. Бид ЗҮЦХА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийг тууштай ашигласан байдлыг авч үзсэн. Мөн бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.

Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл ("Бусад хэсэг") багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Жилийн тайлангийн "Бусад хэсэг"-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлнйн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглах эрх бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй

Санхүүгийн тайлангнйн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлиэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

Shape the future with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төрийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглах эрх бүхийэтгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Адриан Чу болно.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан:

БУЛАНБАЙН ХАБЫЛХАЙРАТ
Захирал

Баталсан:

АДРИАН ЧУ
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 13

ТӨРИЙН БАНКНЫ ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 31

Төгрөгөөр

Дансны код	Дансны нэр	Дүн
	Тэнцлийн гадуурх данс,уул	15,384,446,565,680.7
61000000	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөөд хамаарах үүрэг	25,495,359,839.2
61010000	Банкны гаргасан баталгаа	-
61020000	Импортын баталгаа	-
61030000	Экспортын баталгаа	-
61040000	Урьдчилгаа төлбөрийн баталгаа	32,952,025.0
61050000	Банкны гаргасан батлан даалт	-
61060000	Вексэлийн батлан даалт	-
61070000	Харилцагчийн өмнөөс гаргасан аккредитивын баталгаа даалт	
61080000	Тендерийн батлан даалт	2,869,142,957.3
61090000	Гүйцэтгэлийн батлан даалт	9,252,715,442.2
61100000	Импортын аккредитив	228,565,439.4
61110000	Экспортын аккредитив	-
61120000	Зээлийн шугам	3,813,622,814.1
61130000	Овердрафтын зээлийн шугам	9,298,361,161.2
61140000	Худалдсан зээлтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг	-
61150000	Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг	-
61160000	Хамтын зээлжүүлэхээр хүлээсэн үүрэг	-
61170000	Бусад болзошгүй үүрэг	-
62000000	Барьцаа хөрөнгө	12,339,793,732,519.6
62010000	Үнэт цаас	-
62020000	Хөдлөх хөрөнгө	279,670,311,193.8
62030000	Үл хөдлөх хөрөнгө	4,587,281,916,693.8
62040000	Үнэт металл	-
62050000	Бусдаас авсан баталгаа, батлан даалт	259,071,118,343.6
62060000	Бусад барьцаа	7,213,771,286,288.4
63000000	Тэнцлээс хассан хөрөнгө	106,188,610,680.6
63100000	Балз, санхүүгийн байгууллагад байрлуулсан хөрөнгө	-
63200000	Үнэт цаасны эрсдэлийн сангаар хассан үнэт цаас	-
63300000	Зээлийн эрсдэлийн сангаар хассан зээл	1,220,847,696.1
63400000	Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хассан хөрөнгө	-
63500000	Үнэт металлын эрсдэлийн сангаар хассан үнэт металл	-
63600000	Авлагын эрсдэлийн сангаар хассан авлага	453,275,315.2
63700000	Хүчингүйдүүлж тооцохыг зогсоосон хүү	104,514,487,669.3
64000000	Дериватив санхүүгийн хэрэгсэл	1,986,767,682,746.4
64100000	*Свап гэрээ*	11,360,152,746.4
64101000	Гадаад валютын арилжааны авлага	5,678,640,000.0
64102000	Гадаад валютын арилжааны өглөг	5,681,512,746.4
64103000	Үнэт металлын арилжааны авлага	-
64104000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64105000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64106000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64200000	*Форвард*	-
64201000	Гадаад валютын арилжааны авлага	-
64202000	Гадаад валютын арилжааны өглөг	-
64203000	Үнэт металлын арилжааны авлага	-
64204000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64205000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64206000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64300000	*Своп*	1,975,407,530,000.0
64301000	Гадаад валютын арилжааны авлага	991,901,220,000.0
64302000	Гадаад валютын арилжааны өглөг	983,506,310,000.0
64303000	Үнэт металлын арилжааны авлага	-
64304000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64305000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64306000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64307000	Тогтмол хүүгийн түвшний своп	-
64308000	Хөвөгч хүүгийн түвшний своп	-
64309000	Индекс	-
64310000	Бусад	-
64400000	*Опцион*	-
64401000	Гадаад валютын арилжааны авлага	-
64402000	Гадаад валютын арилжааны өглөг	-
64403000	Үнэт металлын арилжааны авлага	-
64404000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64405000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64406000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64407000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага	-
64408000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг	-
64500000	*Фьючерс*	-
64501000	Гадаад валютын арилжааны авлага	-

64502000	Гадаад валютын арилжааны өглөг	-
64503000	Үнэт металлын арилжааны авлага	-
64504000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64505000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64506000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64507000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага	-
64508000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг	-
64600000	*Бусад дериватив*	-
64601000	Гадаад валютын арилжааны авлага	-
64602000	Гадаад валютын арилжааны өглөг	-
64603000	Үнэт металлын арилжааны авлага	-
64604000	Үнэт металлын арилжааны өглөг	-
64605000	Үнэт цаасны арилжааны авлага	-
64606000	Үнэт цаасны арилжааны өглөг	-
64607000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага	-
64608000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг	-
64700000	*Хэрэгжээгүй орлого, зардлын нэвэр дүн*	-
65000000	**Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө**	-
65100000	*Үнэт цаасны хадгаламж (кастодиан)*	-
65110000	Компанийн хувьцаа, нэрлэсэн үнээрээ	-
65120000	Компанийн бонд, нэрлэсэн үнээрээ	-
65130000	Компанийн вексель, нэрлэсэн үнээрээ	-
65140000	Эргүүлэн худалдах буюу худалдан авах нөхцлөөр авсан үнэт цаас	-
65150000	Засгийн газрын бонд, нэрлэсэн үнээрээ	-
65160000	Орон нутгийн бонд, нэрлэсэн үнээрээ	-
65170000	Засгийн газрын үнэт цаас, нэрлэсэн үнээрээ	-
65180000	Бусад зүйлс, нэрлэсэн үнээрээ	-
65200000	*Бусад хөрөнгө*	-
66000000	**Барьцаанд тавьсан хөрөнгө**	188,122,272,783.0
66010000	Мөнгөн хөрөнгө ба бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	-
66020000	Үнэт цаас	188,122,272,783.0
66030000	Авлага	-
66040000	Зээл	-
66050000	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-
66060000	Барилга, байгууламж	-
66070000	Үнэт металл	-
66080000	Бусад хөрөнгө	-
67000000	**Төлбөрийн чадваргүй бусад данс**	738,078,907,112.0
67010000	Гадаад хөрөнгийн санхүүжилтэнд зориулан гадаадын банкуудад нээсэн шугам	-
67020000	Гадаадын банкуудад нээсэн бусад шугам	-
67030000	Худалдааны санхүүжилтээр дотоодын банкуудад нээсэн шугам	-
67040000	Дотоодын банкуудад нээсэн бусад шугам	-
67050000	Бусад компани, банкны өмнөөс удирдах хөрөнгө	-
67060000	Хамтын хөрөнгө оруулагч банкинд хамаарах хэсэг	-
67070000	Эрсдэлийг шилжүүлж худалдсан хэсэг	653,708,892,737.8
67080000	Үүрэг хүлээлгүй батлагдсан батлагааны шугам	-
67090000	Үүрэг хүлээлгүй батлагдсан хэсгийн шугам	-
67100000	Хүлээж авсан дотоодын инкасс	-
67110000	Хугацаандаа төлөгдөөгүй дотоодын инкасс	-
67120000	Хүлээж авсан гадаадын инкасс	-
67130000	Хугацаандаа төлөгдөөгүй гадаадын инкасс	-
67140000	Гадаги явуулсан нөхөмжлөл	-
67150000	Гадаас ирүүлсэн нөхөмжлөл	-
67160000	Хадгалсан үнэ бүхий зүйл	31,165.0
67170000	Барьцаалхаар авсан гадаадын чек	-
67180000	Борлуулсан үнэт цаас, чек	-
67190000	Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, чекийн загвар	61,747.0
67200000	Банкны ажилд хэрэглэж буй тэмдэгүүд	9,924.0
67210000	Цахим карт	13,929.0
67220000	Бусад	84,369,897,609.2

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал Ө.Гантөр

Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч Д.Сугар

Санхүүгийн газрын захирал Д.Жаламбаа

Тайлан мэдээнийн хэлтсийн захирал Н.Энхтайван

Тайлан мэдээнийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Буянтогтох

Тайлан мэдээний хэлтсийн хяналтын мэргэжилтэн Д.Наранцацрал

Тайлан мэдээний хэлтсийн тайлангийн мэргэжилтэн Г.Ганбаяр

Хавсралт №4

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
/2025.01.01-2025.12.31/

2026.01.05

Тайлант хугацаанд "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1 дэх заалтад "Банкны "Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасан нийтлэг нөхцөлөөр банкны холбогдох бодлого, журамд заасан шаардлагыг хангуулан, олон нийтэд санал болгож буй ердийн журмаар бизнесийн болон төслийн зээлээс бусад жижиг зээл, харилцах, хадгаламж болон карт, цахим банкны үйлчилгээтэй холбогдох хэлцэл байгуулах" гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын эрх хэмжээний хүрээнд 2025 онд нийт 2,336 удаагийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн. Үүнд:

1. Карт - 149
2. Зээл - 104
3. Хадгаламж барьцаалсан онлайн зээл - 1752
4. Харилцах хадгаламж - 146
5. Автомат хуримтлал - 4
6. Дамжуулалтын түр данс - 5
7. Батлан даалтын эх үүсвэр - 3
8. Интернэт банк - 11
9. Мерчант түр данс - 9
10. Мессеж мэдээ - 13
11. Мобайл банк - 26
12. Тэмдэгтийн хураамжийн авлага - 1
13. Өглөг / mnt - 88
14. Хураамжийн авлага /mnt/ - 5
15. Хувийн дугаар - 14
16. Гэрээ - 6

Дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь "Төрийн банк ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6.1-д "Банкны "Үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасан нийтлэг нөхцөлөөр банкны холбогдох бодлого, журамд заасан шаардлагыг хангуулан, олон нийтэд санал болгож буй ердийн журмаар *бизнесийн болон төслийн зээлээс бусад* ***жижиг зээл, харилцах, хадгаламж болон карт, цахим банкны үйлчилгээтэй холбогдох хэлцэл байгуулах***" гэж заасан зохицуулалтад нийцсэн байна.

ХЯНАСАН:
КОМПЛАЙНСЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ Б.СУГАР

БОЛОВСРУУЛСАН:
КОМПЛАЙНСЫН ГАЗРЫН
ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН Ч.ТҮВШИНБАЯР

Хавсралт №5

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь Төрийн өмчит "Төрийн банк"-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан "Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Төрийн банк" ХК нь системийн нөлөө бүхий банкнуудаа түүчээлж нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д үнэт цаасаа бүртгүүлэн, нийт гаргасан хувьцааныхаа 5.71 хувийг олон нийтэд гаргаснаар 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.

"Төрийн банк" ХК нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Гүйцэтгэх захирал, Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Эрсдэл, санхүү хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч, 5 Дэд захирал, 16 газар, 23 хэлтэс, 10 алба, Улаанбаатар хотод 81 нэгж, Орон нутагт 408 нэгж, БНСУ-д байрлах төлөөлөгчийн газартай буюу нийт 490 нэгж, 257 АТМ болон 10,357 картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашид "Төрийн банк" ХК нь стратеги, бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөлтийн хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, эрсдэлийн удирдлага ба дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, тогтвортой хөгжил болон ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөлт, нөлөөллийн тайлагналыг сайжруулах, компанийн засаглалын чанарыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигчид:

"Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшлийн бүтцийн хувьд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Сангийн яам 49.26 хувь, Хадгаламж даатгалын корпораци 45.03 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна.



Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу 2025 оны "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, "Төрийн банк" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, "Төрийн банк" ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан, "Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулж, "Төрийн банк" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулав.

"Төрийн банк" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохион байгуулж, хурлын тэмдэглэл, шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын эрхийн тооллогын баримт бичгийн баталгаажуулсан хувийг 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монголбанканд хүргүүлэв.

Төлөөлөн удирдах зөвлөл:

"Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шинэчлэгдэн батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл */цаашид "ТУЗ" гэх/*-ийн ээлжит хурлыг батлагдсан хуваарийн дагуу, шаардлагатай нөхцөлд ээлжит бусаар тухай бүр зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд ТУЗ нь банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дунд хугацааны стратеги, зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна.

ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 11 удаа хуралдаж, 48 асуудал, мөн ТУЗ-ийн ажиллах журамд заасан нөхцөл, журмын дагуу 13 танилцуулах хуудсаар 19 асуудлыг гишүүдэд хүргүүлж, саналыг бичгээр авч шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд ТУЗ нийт 67 асуудлыг шийдвэрлэж, 99 тогтоол гарган, 10 үүрэг даалгавар өгч, хууль тогтоомж болон банкны дүрэмд заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн хурлын ирц тогтмол 66.6 хувиас дээш хувьтай байсан бөгөөд ТУЗ-ийн гишүүд үүрэг, хариуцлагын хэрэгжилтийн хүрээнд хуралдааны оролцоог тогтмол ханган ажилласан.

Хууль тогтоомж болон тус банкны дүрмээр "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийг нийт 9 гишүүн /5 ердийн, 4 хараат бус/-ий бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосон бөгөөд ТУЗ-ийн даргаар Б.Тэлмүүн, ердийн гишүүдээр Б.Ганбат, Г.Золбоо, Х.Пүрэвсүрэн[1], Л.Сонор[2], хараат бус гишүүдээр М.Батжаргал, С.Цэнд-Аюуш, З.Оюунцацрал[3], Б.Цэвэгжав[4] нар ажиллаж байсан.

Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайдаас ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг 2025 оны 3 дугаар сард ирүүлж, холбогдох материалыг Монголбанканд хүргүүлэн, нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр томилоход татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг хүлээн авсан.

Улмаар тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь кумулятив аргаар шинэчлэн сонгох асуудлыг хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн ажил, албан тушаалын өөрчлөлттэй холбоотойгоор уг асуудлыг 2026 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Тайлан хүргүүлэх үеийн байдлаар "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр Г.Золбоо[5], ердийн гишүүдээр Б.Ганбат, Х.Пүрэвсүрэн, хараат бус гишүүдээр М.Батжаргал, С.Цэнд-Аюуш, З.Оюунцацрал, Б.Цэвэгжав нар ажиллаж, хууль тогтоомж болон банкны дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд банкны үйл ажиллагааны тогтвортой байдал, стратеги, бодлого, эрсдэлийн удирдлага, санхүүгийн хяналтын чиглэлээр шийдвэр гарган ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүдэд 2025 онд "Төрийн банк" ХК-ийн үйл ажиллагааны тайлан, комплайнсын үйл ажиллагаа, мэдээллийн технологийн аудитын тайлан, МУТСТ дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн тайлан, банкны эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан, Дотоод аудитын газрын тайлан, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг тус тус танилцуулж, цаг үеийн шаардлагатай болон холбогдох мэдээллээр хангасан. Мөн ТУЗ-ийн гишүүдийг чиглүүлэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд ТУЗ-ийн хараат бус гишүүд ЕҮ байгууллагаас "Уур амьсгалын эрсдэлийн удирдлага"-ын чиглэлээр үзүүлсэн зөвлөх үйлчилгээний хүрээнд зохион байгуулсан 2 удаагийн сургалт болон СТОУС S1, S2 тайлагналын цахим сургалтад хамрагдсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл:

---

[1] Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын 51 дүгээр тогтоолын дагуу түр томилогдсон.
[2] Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдөр гаргасан.
[3] Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын 47 дугаар тогтоолын дагуу түр томилогдсон.
[4] Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын 48 дугаар тогтоолын дагуу түр томилогдсон.
[5] "Төрийн банк" ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн 2026 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн. Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайдын 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 01/779 албан тоотоор ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр Г.Золбоог түр томилох тухай удирдамж ирүүлснээр Г.Золбоог ТУЗ-ийн 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 18 дугаар тогтоолын дагуу ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон болно.

ТУЗ-ийн даргын үүрэг гүйцэтгэгч:

- Г.Золбоо - Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. МУИС–ийн Эдийн засгийн сургуулийн банкны эдийн засагч бакалавр, ИБУИНВУ-ын Уельсийн их сургуулийн олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2022 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

ТУЗ-ийн гишүүд:

- Б.Ганбат - ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид Хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995 оноос хойш Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.

- Х.Пүрэвсүрэн - МУИС-ийн нягтлан бодогч, эдийн засагч магистр, Голланд Улсын Маастрихтийн менежментийн их сургуульд нягтлан бодох, эдийн засгийн менежментийн чиглэлээр тус тус боловсрол эзэмшсэн. 1992-1996 онд СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1996-1997 онд “Говь” ХК-д эдийн засгийн хэлтсийн дарга, 1997-1999 онд Төрийн өмчийн хороонд албаны дарга, 1999-2016 онд Сангийн яаманд газрын дарга, Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан ажлын туршлагатай.

- Хараат бус гишүүн М.Батжаргал - Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Арбитр - Ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн С.Цэнд-Аюуш - Санхүүч, ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуульд санхүүч бакалаврын зэргээр боловсрол эзэмшсэн. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн З.Оюунцацрал - Эдийн засгийн коллежийн банк, зээлийн эдийн засагч бакалавр, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийн бизнесийн удирдлагын магистр, зэргээр боловсрол эзэмшсэн. СЭЗИС-ийн

удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. 1996 оноос өнөөг хүртэл СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, профессороор ажилласан туршлагатай.

- Хараат бус гишүүн Б.Цэвэгжав - СЭЗИС-ийн банкны удирдлагын бакалавр, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2002-2014 онд Капитрон банканд нягтлан бодогч, эдийн засагч, дилер, салбарын захирал, 2014-2015 онд Богд банк байгуулах төсөл, хөрөнгийн удирдлага хариуцсан гишүүн, 2015-2017 онд "Мегамакс групп" ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2023 онд "Эрдэнэс Монгол" ХХК-д албаны дарга, хэлтсийн дарга, 2022-2023 онд "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Эрдэнэс силвер ресурс" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Метан газ ресурс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан ажлын туршлагатай.

Гүйцэтгэх захирал:

- Ө.Гантөр - Төрийн банкны Гүйцэтгэх захирал. СЭЗДС-ийг Банк санхүүч, бакалавр, KDI School of PPM Korea сургуулийг Удирдлагын ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1996-1997 онд "Монком" ХХК-д Нягтлан бодогч, 1997-1999 онд "ММ Инвест" банканд эдийн засагч, 1999-2011 онд Монголбанканд Хянан шалгагч, Ахлах хянан шалгагч, 2011-2013 онд Төрийн банканд Дэд захирал, 2013-2018 онд Монголбанканд Ахлах хянан шалгагч, 2018-2019 онд Төрийн банканд Байгууллагын банкны газрын захирал, 2019-2020 онд Төрийн банканд Тэргүүн дэд захирлаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод:

Тус банкны ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 56 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт оруулсан.

Аудитын хороо

Хорооны дарга:	С.Цэнд-Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	З.Оюунцацрал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Х.Пүрэвсүрэн	ТУЗ-ийн гишүүн

Эрсдэлийн удирдлагын хороо

Хорооны дарга:	З.Оюунцацрал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	Б.Цэвэгжав	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Г.Золбоо	ТУЗ-ийн гишүүн

Нэр дэвшүүлэх хороо

Хорооны дарга:	Б.Цэвэгжав	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	М.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Х.Пүрэвсүрэн	ТУЗ-ийн гишүүн

Цалин урамшууллын хороо

Хорооны дарга:	М.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гишүүд:	С.Цэнд-Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Х.Пүрэвсүрэн	ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүд даргалан ажиллаж байна.

Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплайнсын хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангаж ажиллах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Аудитын хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2025 онд нийт 23 удаа хуралдан, 54 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 55 шийдвэр гарган, 32 үүрэг даалгавар өгч, ТУЗ шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо банкны үйл ажиллагааны чиглэл бүрд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлыг улирал бүр тогтмол зохион байгуулж, 2025 онд нийт 14 удаагийн хурлаар 49 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 32 шийдвэр гарган, 17 үүрэг даалгавар өгч, Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн, хорооны эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр

дэвшүүлэх, сонгон шалгаруулах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо нийт 7 удаа хуралдаж, 16 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад шаардлагатай санал дүгнэлт, мэдээллээр ханган ажилласан.

Цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь Банкны алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлийг хангасан, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, банкны ашиг болон ажлын гүйцэтгэлд суурилсан ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг.

Банкны цалин урамшууллын бодлого тогтворжсон, шинэчлэх шаардлагагүй байсантай холбоотойгоор тус хороо 2025 онд 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэн шийдвэрлэж хорооны эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын алба

ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан “Компанийн засаглалын кодекс”, Монголбанкнаас батлсан “Банкны зохистой засаглалын журам”-ын хэрэгжилтийг хангуулах, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, түүний дэргэдэх хороодын хурлыг зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудлын хууль зүйн үндэслэл, холбогдох бусад эрх зүйн хэмжээний нийцэл зэргийг хянан ажилласан байна.

Тайлант хугацаанд “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, түүний дэргэдэх хороодын нийт 70 удаагийн хурлыг зохион байгуулж, 188 асуудал хэлэлцэхэд оролцон ажиллаж, 197 шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг нягтлан, хурлуудын тэмдэглэлийг холбогдох журамд тусгасан хугацаанд багтаан хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, ТУЗ-ийн дарга, гишүүдээр хянуулан баталгаажуулж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан нэгтгэж, ТУЗ-д танилцуулж ажилласан болно.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн бүтэц, хараат бус байдал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, аудит, хяналт, эрсдэлийн удирдлага, цалин урамшууллын бодлого, оролцогч талуудын эрх ашиг, компанийн соёл, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах чиглэлээр холбогдох бодлого, журам, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн Монголбанканд банкны зохистой засаглалын үнэлгээний тайланг, Санхүүгийн зохицуулах хороонд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг тус тус тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.

“Төрийн банк” ХК нь Монголбанкны 2024 оны банкны зохистой засаглалын үнэлгээгээр “Сайн засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаа хэвийн банк” гэж үнэлэгдэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны зохистой засаглалын үнэлгээгээр 95.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн санал, зөвлөмжид үндэслэн цаашид ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, тайлагналын чанар, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт болон оролцогч талуудын эрх ашгийн тайлагналыг илүү хэмжигдэхүйц болгох чиглэлээр ажиллана.

Мэдээллийг гаргасан:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Э.Уянга/